

“ТАВАН ТОЛГОЙ” ХК-ИЙ НҮҮРС БОРЛУУЛАХ ЖУРАМ

Нийтлэг зүйл.

“Таван толгой” ХК-ий экспортоос бусад дотоодын нүүрс борлуулах аливаа харилцааг энэхүү журамаар зохицуулна. Энэхүү журмыг “Таван толгой” ХК-ий хүрээнд дагаж мөрдөнө.

Нэг. Даланзадгад суман дахь Нүүрс борлуулах цэгийн нүүрсний борлуулалт /НБЦ/

1.1. Нүүрс борлуулах цэгийн нүүрсийг санхүүгийн шийдвэрээр тухай бүр нь компаний тээврийн машинаар ачиж захиалга өгсөн НБЦ-т буулгана.

1.2. Хэрэглэгчид 1 тн нүүрсийг 16000 төгрөгөөр худалдан авна.

1.3. Хэрэглэгчдэд нүүрс борлуулах цэгээс 2 тн хүртэлх хэмжээний нүүрсийг нэг удаагийн борлуулалтаар олгоно.

1.4. Борлуулагч нар бэлэн мөнгөөр тооцоог хийнэ.

1.5. НБЦ-ийн ажиллах цагийн хуваарийг улирлын чанартай өөрчилж байх бөгөөд борлуулагч нар компаниас баталсан цагийн хуваарийн дагуу ажиллана. Нүүрс борлуулах цэгийн борлуулагч нар Даланзадгад дахь компаний төлөөлөгчийн газраас өглөө 7:30 цагаас наръяд авч ажилдаа гарна.

1.6. Борлуулагч нар тухайн өдрийн орлогоо өдөрт нь банкаар тушааж, сар бүрийн 30-нд тооцоо нийлж байна.

1.7. Хэрэглэгчдэд борлуулсан нүүрсээ өдөр бүр Microsoft excel файл хэлбэрээр дэлгэрэнгүй маягтаар гаргах бөгөөд 7 хоног тутам санхүүд ирүүлнэ. /e-mail болон эх хувиар/

1.8. НБЦ-ийн чулуулгийг улирал тутамд маркшейдеруудаар хэмжилт хийлгэн хогийн цэгт хаяна.

Хоёр. Дотоодын нүүрсний борлуулалт.

2.1. Өмнөговь аймгийн ИТХ-аас компаний ТУЗ-д өгсөн чиглэлийн дагуу зөвхөн Өмнөговь аймгийн харъяат айл, өрх сумдын ОНӨААТҮГазар /сумдын эрчим/, төсвийн байгууллагуудад 8000 /НӨАТ ороогүй/ төгрөгөөр нүүрсийг борлуулна.

2.1.1. 10 тн хүртэлх хэмжээний нүүрсийг гэрээгүй худалдан авч болно.

2.1.2. 10-с доош тн нүүрс авч буй хэрэглэгч уурхайн борлуулагчаас зөвшөөрлийн бичиг авч, цэвэр болон ачаатай жинг пүүлүүлэн ачилт хийлгэх бөгөөд нүүрсний тооцоог бэлэн мөнгөөр хийнэ. /жолоочид бэлэн мөнгөний баримт, нүүрсний падааны нэг хувийг өгнө/

2.1.3. Иргэдэд 11-20 тн хүртэлх нүүрсийг хүсэлтийн дагуу гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулан олгоно.

2.1.4. Гэрээ байгуулж байгаа иргэн дараах материалыг бүрдүүлнэ.

- Иргэний үнэмлэхний хуулбар
- Ачих машины гэрчилгээний хуулбар
- Нүүрс хүссэн өргөдөл /компьютероор бичсэн байна/
- Оршин суугаа газрын тодорхойлолт
- Нүүрсний хэрэгцээг тодорхойлох баримт бичиг /зуухны хүчин чадал/

2.2. Бусад худалдан авагчид, Өмнөговь аймгийн болон бусад аймгийн ААН, хувь хүн, байгууллагад 15000 /НӨАТ ороогүй/ төгрөгөөр борлуулна.

2.2.1 10 тн хүртэлх хэмжээний нүүрсийг гэрээгүй худалдан авч болно.

2.2.2. 10-с доош тн нүүрс авч буй хэрэглэгч уурхайн борлуулагчаас зөвшөөрлийн бичиг авч, цэвэр болон ачаатай жинг пүүлүүлэн ачилт хийлгэх бөгөөд нүүрсний тооцоог бэлэн мөнгөөр хийнэ. /жолоочид бэлэн мөнгөний баримт, нүүрсний падааны нэг хувийг өгнө/

2.2.3. Иргэдэд 11-20 тн хүртэлх нүүрсийг хүсэлтийн дагуу гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулан олгоно.

2.2.4. Гэрээ байгуулж байгаа иргэн дараах материалыг бүрдүүлнэ.

- Иргэний үнэмлэхний хуулбар
- Ачих машины гэрчилгээний хуулбар
- Нүүрс хүссэн өргөдөл /компьютероор бичсэн байна/
- Оршин суугаа газрын тодорхойлолт
- Нүүрсний хэрэгцээг тодорхойлох баримт бичиг /зуухны хүчин чадал/

2.2.5. ААНБ-ын нүүрс худалдан авах хүсэлтийг үндэслэн гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулан олгоно.

2.2.6. ААНБ нь дараах материалыг бүрдүүлнэ.

- Байгууллагын хүсэлт албан тоотоор
- Нүүрсний ашиглагдах хэмжээг тодорхойлсон баримт бичиг /зуухны хүчин чадал/
- Үйл ажиллагаа явуулж байгаа нутаг дэвсгэрийн эрх бүхий байгууллагын тодорхойлолт

Жич: Хэрэглэгч уурхайн борлуулагчаас зөвшөөрлийн бичиг авч, цэвэр болон ачаатай жинг пүүлүүлэн ачилт хийлгэх бөгөөд нүүрсний тооцоог бэлэн болон бэлэн бус хэлбэрээр хийж болно. / жолоочид бэлэн мөнгөний баримт, нүүрсний падааны нэг хувийг өгнө/

2.3. Гэрээ байгуулсан байгууллагууд нүүрс ачихдаа тухайн байгууллагын зөвшөөрөл албан тоотыг авч ирнэ.

2.4. Энэхүү журам нь 2013.10.07-2013.12.01-ний өдрийг хүртэл хүчинтэй болно.